



## ТӨРИЙН ТУСГАЙ АЛБАН ХААГЧДЫН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2021 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/᠑᠐

Улаанбаатар хот

“Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сарын аян”-ыг зохион байгуулах тухай

Монгол улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2, 20.2.3, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 35 дугаар зүйлийн 35.1, Эмнэлгийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1.1, Хөдөлмөрийн дотоод журмын 5 дугаар зүйлийн 5.3.15, 57 дугаар зүйлийн 1.4-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтын тогтолцоог сайжруулах, ажлын байранд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартыг хангах, болзошгүй эмнэлзүйн болон эмнэлзүйн бус эрсдэл болон (Ковид-19) халдвараас иргэд, үйлчлүүлэгч, албан хаагчдыг урьдчилан сэргийлэх зорилгоор Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяныг “Эрсдэлгүй эмнэлгийн төлөө хамтдаа” уриан дор 2020 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс 05 дугаар сарын 10-ны хооронд зохион байгуулж, хийх ажлын төлөвлөгөөг нэгдүгээр хавсралтаар, тасаг, алба, нэгжүүдийн бүтээлч санаачилгыг дүгнэх удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяны үйл ажиллагааны хүрээнд албан хаагчдад ажлын байран дахь халдвар хамгаалал, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих, иргэд үйлчлүүлэгчдэд ээлтэй орчинг бүрдүүлэх чиглэлээр идэвх санаачлага гарган ажиллахыг тасгийн эрхлэгч, албадын дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллаж, шинэ санаачлага, бодит үр дүн гарган манлайлан ажилласан тасгийн эрхлэгч, албадын дарга болон албан хаагчдыг үр дүнгийн урамшуулалд шагнуулах саналыг эмнэлгийн захиралд танилцуулахыг Стратеги төлөвлөлт, эрхэлсэн дэд захирал (хошууч Д.Отгонбаатар), ХАБЭА-н мэргэжилтэн Ц.Баяртогтох нар

202100382

тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын алба (дэд хурандаа Р.Оюунчимэг) нарт тус тус даалгасугай.

4. Энэхүү аяны үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг батлагдсан төсвийн зардлаас гаргахыг Санхүү хангамжийн албаны дарга(хошууч Д.Гантуяа)-д зөвшөөрсүгэй.

ЗАХИРАЛ,  
ДЭД ХУРАНДАА



Х.БАТ-ИРЭЭДҮЙ

Эмнэлгийн захирлын 2021 оны 04 дүгээр сарын 29 ний өдрийн А/80 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



**“ ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН САРЫН АЯН”- Ы ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин	Хугацаа	Хариуцах эзэн
1	“ХАБЭА-н тухай хууль, ажилчдын эрх үүрэг”, мөрдөх дүрэм, журам техникийн зохицуулалт, стандарт зөвлөмж сэдвүүдээр цахим сургалтыг зохион байгуулах	Ажилтан албан хаагчид ХАБЭА-н бүхий л талаарх мэдлэг мэдээлэл сайжирсан байна.	4/10–5/10	ХАБЭА-н зөвлөл СЭШХААлба Сургалт зохион байгуулагч байгууллага
2	Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэх ажлын байрны судалгаа гарган, нэн шаардлагатай ажлын байруудад мэргэжлийн байгууллагаар нөхцөлийн үнэлгээг хийлгэн, үр дүнг хамт олонд мэдээлэн ажиллах	Хөдөлмөрийн үнэлгээ хийлгэн эрсдэлээс сэргийлэн ажиллана.	4/10–5/10	ХАБЭА-н зөвлөл СЭШХААлба ТХАлба Сургалт зохион байгуулагч байгууллага
3	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин, (COVID-19) цар тахлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээ, мэдээлэл, ярилцлага, контент (постер) гарын авлага зэргийг бэлтгэн байгууллагын фейсбүүк,-вэб сайтаар олон нийтэд түгээн сурталчлах	Ажилтан албан хаагчдыг “COVID-19” халдвараас болон хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн эрсдэлээс хамгаална	4/10 – 5/10	ХАБЭА-н зөвлөл Нийт тасаг, албад
4	Тасаг, алба бүр ажлын байрандаа “COVID-19” халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр, болон Хөдөлмөрийн аюулгүй байдал,эрүүл ахуйн чиглэлээр бүтээлч ажлыг хэрэгжүүлэн, үр дүнг тооцон ажиллах	Нийт ажилтан албан хаагчдыг хамруулсан байна.	4/10- 5/10	ХАБЭА-н зөвлөл
6	“Халдварын эсрэг хамтдаа” зорилтод үйл ажиллагааг зохион байгуулах	Үр дүнг тооцон ажиллана.	05/07	ХАБЭА-н зөвлөл
7	Аяны хүрээнд хийсэн ажлуудын тайланг нэгтгэн хамт олны, холбогдох хурлуудад мэдээлэх			

Эмнэлгийн захирлын 2021 оны 04  
дүгээр сарын 07-ний өдрийн 180  
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

**ТАСАГ, АЛБА НЭГЖҮҮДИЙН БҮТЭЭЛЧ САНААЧИЛГЫГ ДҮГНЭХ ХУУДАС**

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Ажлын тайлан авах хугацаа	Үр дүнг тооцох		
			Гүйцэтгэл (тоо, чанар) (0-10)	Санхүүжилт (0-10)	Үр нөлөө (0-10)
1	Тасаг, алба бүр ажлын байрандаа "COVID-19" халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр бүтээлч ажлыг хийж, хэрэгжүүлэн үр дүнг тооцон ажилласан байдал	V/7			
2	Нийт тасаг, алба ажилтан, алба хаагчдыг ажлын байран дээрх ХАБЭА-н чиглэлээр болзошгүй эрсдэлээс сэргийлэх бодит ажлыг хийж, үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байдал	V/7			
3	Нийт тасаг алба ажлын байран дахь эрсдэлийн үнэлгээг тооцож, арга хэмжээ авсан байдал	V/7			
4	<b>Нийт оноо</b>				

- Жич:** 1. Хэрэгжих хугацаа: 2021 оны 4 дүгээр сарын 10-ны өдрөөс 2021 оны 5 дугаар сарын 10-ны хооронд явагдана.  
2. 1, 2, 3 байр шалгаруулан шагнаж урамшуулна.

----o0o----